

Гадаадын хөрөнгө оруулагч уу? Залилагч уу?

Хөгжиж буй улс орнуудын иргэд, ялангуяа хөрөнгө санхүүгийн түршлага, мэдлэг дутмаг иргэд, хуулийн этгээдүүдийг онилж, хууран мэхлэх, залилах гэсэн үйлдэл байнга гардаг гэдгийг та бид бүгд мэднэ. Нэг үеэ бодвол иргэд рүү чиглэсэн янз бүрийн интернэт, кибер залилангийн талаар (тухайлбал сугалаанд хожсон, их хэмжээний хөрөнгө өвлөн авсан, хамтран ажиллах гэх мэт олон төрлийн и-мэйл, мессеж ирүүлэх зэрэг) иргэд илүү мэдээлэлтэй болсон бөгөөд тийм төрлийн залиланд автахаа больсон нь сайшаалтай.

Харин бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулалт хайсан компаниудыг онилсон хуурамч хөрөнгө оруулагч нарыг хэрхэн таньж мэдэх бэ? Иймэрхүү төрлийн залилан хийх гэж байгаа этгээдүүд олон янзын арга барил, зохион байгуулалттай байх боломжтой тул аль болох олон талаас нь нягтлах, аливаа шийдвэр гаргахын өмнө мэргэжлийн зөвлөгөө авч байх нь зүйтэй юм. Эдгээр залилан хийх гэж буй этгээдүүдийг таньж мэдэхэд туслах боломжтой зарим нэг зөвлөгөө, анхаарах асуудлуудыг товч дурдъя.

1. **Нэр, хаяг, имэйл хаяг, ажлын хаяг, вэбсайт гэх мэт үндсэн мэдээлэл болон тэдгээрийн уялдаа**

Хамгийн эхний шалгах, анхаарах асуудлын нэг бол мэдээж тухайн хөрөнгө оруулагчийн нэр, хаяг, иргэншил, имэйл хаяг, ажлын хаяг, вэбсайт гэх мэт асуудлууд болно. Мөн эдгээр асуудлуудын хоорондын авцалдаа, уялдааг анхаарах ёстой. Өндөр үнийн дүнтэй хөрөнгө оруулалт хийхээр амлаж байгаа мэргэжлийн хөрөнгө оруулагч нар “gmail”, “yandex”, “nader” гэх мэт хувийн, үнэ төлбөргүй имэйл хаягийг албан ажилд ашиглахгүй нь ойлгомжтой. Нөгөө талаас дэлхийн санхүүгийн төвүүдэд байршилтай, тухайлбал АНУ-ын Нью Йорк хотын Валл стрийт-д байршилтай гэж ажлын хаягаа нэрийн хуудсан дээрээ бичсэн боловч Англи хэлээр ярьж чадахгүй бол хир үнэмшилтэй бэ?

Зарим залилан хийгчдийн арга илүү нарийсаж, вэбсайтыг мэргэжлийн түвшинд хийсэн байх боломжтой. Гэхдээ вэбсайт дээр бичигдсэн агуулгыг сайн анхаарч үзэж бас болно. Тухайлбал томоохон компани, аж ахуйн нэртэй бараг адилхан нэр өгөх, адилхан лого байршуулах зэрэг үйлдлүүд хийсэн эсэх. Аль эсвэл хүний анхаарах татах, итгэл үнэмшил төрүүлэх үүднээс бизнесийн үйл ажиллагаатай огт хамааралгүй хувийн мэдээллүүд ихээр оруулсан эсэх. Тухайлбал

гадаадын томоохон улс төрч, бизнесменүүдтэй анд нөхөд, ураг төрлийн харьцаатай гэсэн мэдээлэл байх юм бол бүр их эргэлзээ үүсгэнэ. Үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал, ТУЗ-ын гишүүдийн талаарх мэдээлэл оруулсан бол тухайн хүмүүс бодит хүмүүс эсэхийг анхаарахад бас илүүдэхгүй. Хоорондоо авцалдаагүй, эсвэл бизнестэй нь авцалдаагүй баахан хүмүүсийн нэр зураг оруулсан байна уу?

Сүүлийн үед дэлгэрсэн виртуал оффисын хаяг ашиглаж байгаа эсэхийг бас анхаарна уу. Тухайлбал АНУ-ын Нью Йорк хотын Валл стрийт-д виртуал оффисын хаяг ашиглуулдаг бизнес байдаг гэдгийг анхаарна уу.

2. **Ихэвчлэн яаралтай, маш яаралтай хэлцэл хийхийг ятгах**

Бизнест хурд чухал бөгөөд зарим гэрээ хэлцлийг яаралтай хийх хэрэг гардаг. Гэхдээ хэтэрхий яаруулах, тунгаан бодох зай өгөхгүй байх, бусадтай зөвлөх боломж олгохгүй гэнэтийн хүсэлт тавиад эхэлбэл нягтлах шаардлагатай. Тухайлбал маш том боломж олдсон, шийдвэр яаралтай гаргах хэрэгтэй тул яаралтай гэрээ байгуулах, хувьцааны тодорхой хувь шилжүүлэх гэх мэтээр үндсэн бизнесээ судалж ярилцахаасаа өмнө шууд л гэрээ байгуулах гэж оролдож байвал эрсдэлтэй л гэсэн үг.

3. Ихэвчлэн дундын зуучлагч бөгөөд өөрөө шууд хөрөнгө оруулагч биш байх

Томоохон хөрөнгө оруулагч компаниуд ихэвчлэн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авч, дүн шинжилгээ хийж байж хөрөнгө оруулалт хийхийг зорьдог. Тухайлбал хуулийн фирм, аудитын фирм, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг этгээдийг хөлсөлж, тодорхой судалгаа, дүн шинжилгээ хийх нь элбэг. Харин эдгээр мэргэжлийн зөвлөхүүдээс өөр этгээд буюу аливаа дундын зуучлагч байгаа бөгөөд томоохон хөрөнгө оруулагч олж өгнө гэж байгаа бол сайтар анхаарах ёстой. Ялангуяа өөрөө эхлээд тодорхой хэмжээний хувьцаа эзэмшигч болно, улмаар томоохон хөрөнгө оруулалт оруулж ирнэ гэх мэтээр нөхцөл тавих нь шууд эрсдэлтэй болохыг анхаарна уу.

4. Зах зээлийн жишигт нийцээгүй урьдчилгаа төлбөр шаардах

Тухайн хөрөнгө оруулагч залилан хийх гэж байгааг тодорхойлох бас нэг чухал зүйл бол урьдчилгаа төлбөр асуух. Бизнесийн гэрээ хэлцэл байгуулах, хөрөнгө оруулалт хийхтэй холбоотойгоор талууд аливаа урьдчилан гарах зардлыг хэн хэрхэн төлөх талаар тохиролцох нь мэдээж элбэг. Энэ хүрээнд урьдчилгаа төлбөр төлөх, зардлыг хариуцах тохиолдол гарах боломжтой. Гэхдээ төлбөр төлөхдөө хэд хэдэн нөхцөлүүдийг бодолцох шаардлагатай. Тухайн хөрөнгө оруулагч нь үнэхээр итгэл бүхий компани эсэх, эсвэл дээр дурдсан тодорхой бус компани эсэх, гэрээ хэлцэл байгуулахаас өмнө төлбөр асууж байгаа эсэх, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ ашиглаж байгаа эсэх зэрэг олон асуудлыг анхаарах шаардлагатай.

Сүүлийн үед гарсан ийм төрлийн залилангийн шинжтэй хэргийн талаар судалж үзэхэд залилан хийх этгээдүүдийн арга нь илүү нарийсаж байгааг анхаарах шаардлагатай байна. Тухайлбал хөрөнгө оруулагч нь АНУ-д цаасан дээр компани байгуулах, уг компаниа АНУ-ын санхүүгийн зохицуулах (хяналтын) байгууллагад бүртгүүлэх гэх мэтээр урьдчилан бэлтгэдэг байна. Дараа нь залилах гэж буй компанидаа их хэмжээний хөрөнгө оруулалт хийх талаар амлаж, үүний урьдчилгаа болгож тухайн өмнө байгуулсан компанийг худалдан авах, худалдан авсны дараа хөрөнгө оруулалтаа компаниудын нэгдэл (merger & acquisition) байдлаар зохион байгуулах, ингэх нь татварын эсвэл бүтэц зохион байгуулалтын хувьд илүү түргэн, шуурхай гэж ойлгуулж болно. Улмаар эхний жижиг компанийг худалдан авахын тулд тодорхой хөрөнгө, тухайлбал 50-250 мянга орчим ам.доллар асууж эхлэх юм бол сайн нягтлах ёстойг анхаарна уу. Ийм төрлийн залилан хийх этгээд нь ихэвчлэн вэбсайт, албан хаяг, виртуал оффис зэргийг ашиглаж байх магадлалтай болно.

Иймд аливаа гэрээ хэлцэл байгуулах, ялангуяа хувьцаагаа шилжүүлэхээсээ өмнө тухайн амлалт өгч байгаа хөрөнгө оруулагчийнхаа талаар сайтар судалж, нягталж байна уу. Энэ удаад зөвхөн залилан хийх зорилготой хөрөнгө оруулагчтай холбоотой зарим зөвлөгөөг өгсөн бөгөөд залилан хийх зорилгогүй ч бусад хууль зөрчсөн үйлдэл хийх зорилготой, тухайлбал “мөнгө угаах зорилготой хөрөнгө оруулагч” нарыг таньж мэдэхийн тулд илүү нарийн судалгаа, шинжилгээ хийх, мэргэжлийн зөвлөгөө авах шаардлагатай болохыг анхаарна уу.

Erdenedalai Odkhuu, Partner
erdededalai@melvilledalai.com
+976 7012 8913

